



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 456

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Хархорин-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 40,077,224.00 (дөчин сая далан долоон мянга хоёр зуун хорин дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.3ам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Хархорин-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, эргэлтийн хөрөнгөд орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Н.Доржсүрэн

Д.НАРАНГЭРЭЛ

132001336

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2021 оны 10  
дугаар сарын 19-ний өдрийн //56.  
дугаар тогтоолын хавсралт

**"Хархорин-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас  
хасах хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын, Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөг)
1	Тоёото маркийн 94-23 ӨВР улсын дугаартай, суудлын автомашин, Арлын дугаар RZJ1200023499	2003/2012	1	28,239,719.00	28,239,719.00
2	Хьюндай маркийн 2404ӨВР улсын дугаартай, ачааны автомашин, Арлын дугаар KMEFD37BPXU434022	1999/2013	1	11,837,505.00	11,837,505.00
	ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН		2		40,077,224.00
			2 (хоёр)		40,077,224.00 (дөчин сая далан долоон мянга хоёр зуун хорин дөрвөн)

Дугаар